

БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГА **Э.БАТТУЛГА**



НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР

**“МИНЖ ГАДААЛУУЛАХ БАЙР БАРИХ”
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: “Минж гадаалуулах байр барих” /Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо/ ажил

Тендерийн дугаар: НБОГ-20/002

**Улаанбаатар хот
2020 он**

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5.1.16-д заасан журмаар "Түлхүүр гардуулах" нөхцөлтэйгээр ажлыг хүлээн авна.
2. Усны барилга байгууламжийн бетон ба төмөр бетон бүтээцийн зураг төслийг боловсруулахдаа "Усны барилга, байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам" /БНБД 33-01-03/ – ыг болон бусад усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох, барилгын норм ба дүрмийг мөрдөнө.
3. Бүтээцийн ус үл нэвчүүлэлт ба хүйтэн тэсвэрлэлтийн шаардлагыг хангах, түүнчлэн тэдгээр тооцооны огтлолууд дах усны эсрэг даралтыг багасгахын тулд дараах арга хэмжээг авч үзсэн байна. Үүнд:
 - А. Зохих маркын ус үл нэвчүүлэлт болон хүйтэн тэсвэрлэлттэй бетоноор устай талын хана, ба гаднах гадаргууг цутгах (ялангуяа усны түвшин өөрчлөгддөг бүсэд) бетонд гадаргуугийн идэвхт нэмэгдэл хэрэглэх (агаар оруулах, уян байлгах зэрэг) байгууламжийн гаднах гадаргууд ус тусгаарлалт болон дулаан-усны тусгаарлалт хийх.
 - Б. Түрэлттэй гадаргуугийн зүгээс болон ашиглалтын үеийн ачааллын нөлөөгөөр суналтад ажиллах барилгын гадаргуу талаас бетон шахагдах . Түрэлттэй талд нь шүүрүүл байгуулах хувилбаруудад техник-эдийн засгийн харьцуулалт хийх үндсэн дээр зохих арга хэмжээг сонгож авна.
4. Усны барилга байгууламжийн бетон нь MNS 2057:86 -ийн шаардлагыг хангасан байна.
5. Барилга байгууламжийн мужийн хамгийн хүйтэн сарын дундаж температурыг БНБД 2.01.01-93-ийн дагуу, мөн ус цаг уурын албаны гаргасан өгөгдлөөр тодорхойлон, хүйтэнд тэсвэрлэлтэй бетоны маркаар хийж гүйцэтгэнэ.
6. Усны түрэлтэд харгалзах бетоны ус үл нэвчүүлэлтийн маркийг тодорхойлж хийж гүйцэтгэнэ. Бетоны ус үл нэвчүүлэлтийн маркийг метрээр илэрхийлэгдэх хамгийн их түрэлтийг бүтээцийн метрээр илэрхийлэгдэх зузаан (түрэлттэй талаас шүүрүүл хүртэлх зай)-д харьцуулсан байдлаар тодорхойлогддох, түрэлтийн хэвгийгээс хамааруулж тогтоох ба барилгатай нийлж байгаа усны температур С –ийг хүснэгт 2-оор буюу Барилгын бүтээцийг зэврэлтээс хамгаалах нормын дагуу идэмхий орчноос нь хамааруулж тогтооно.
7. Минж гадаалуулах байрны урт 1450 сантиметр, өргөн 400 сантиметр байна.
8. Минж гадаалуулах байрны минж сэлэх талбайн ёроолыг газрын хөрснөөс дээш 20 сантиметрийн зайтай цутгана. Энэ нь өвөл ус хальж хөлдөн хагарахаас сэргийлнэ.
9. Хэсэг тус бүрд өндөр 1.2 метр, өргөн 0.6 метрийн хэмжээтэй хаалга хийнэ.
10. Минж гадаалуулах байрны ард хана 15 см, урд хана болон баруун, зүүн талын хананы зузаан 20 см байна.
11. Шалны зузаан 20 см байна. Минж гадаалуулах байрны шалны тэгш хэсгийг 0.5 см уналттай хийнэ.
12. Үнийн санал, ажил гүйцэтгэх хуваарь, гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарийг батлаж ирүүлнэ.
13. Ажлын талбай, түүний байршил, нөхцөл байдалтай газар дээр нь танилцсан байх
14. Усаар норгох, ан цав үүсээгүй байх, өнгөлгөөг сайтар хийх.
15. Ажлын явцад гарсан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаях ба ажил


- дууссаны дараа талбайг цэвэрлэж хүлээлгэн өгнө.
16. Хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг хуульд заасны дагуу мөрдөж, түүнд шаардагдах хөрөнгийг хуулийн дагуу төлөвлөж, ажлын төсөвт багтааж, зарцуулах.
 17. Иргэдийн аюулгүй байдлыг бүрэн хангаж, ажлын байр, зам талбайг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу бэлтгэж, ажлыг аюулгүй гүйцэтгэх нөхцлийг бүрэн хангах, хашаа хамгаалалтыг хийж анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг хийх. Ажилтнууд хамгаалах хэрэгслэлээр бүрэн хангагдсан байна.
 18. Гүйцэтгэгч нь захиалагч байгууллагатай уялдаатай ажиллана.
 19. Ажлыг гүйцэтгэх явцдаа минжний үржүүлгийн байрны тохижилт, зогсоол, явган зам, камер, цахилгаан, интернетийн кабель утсыг гэмтээсэн тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр түргэн шуурхай засварлан захиалагч байгууллагад хүлээлгэн өгнө.
 20. Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрэн хангах, үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна.
 21. Байгалийн гэнэтийн гамшиг, гал түймэр, үер усны гамшигаас сэргийлэн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллана.
 22. Бусад шаардлагатай материалын жагсаалт:
 1. Ус дамжуулах PVC 25-ийн труба 90 метр.
 2. Үүрний ус дамжуулах PVC 20-ийн труба 25 метр.
 3. Троник (25x25)-ийн хэмжээтэй 2 ширхэг.
 4. Булан (20x20)-ийн хэмжээтэй 2 ширхэг.
 5. 25-аас 20-д шилжүүлэгч троник 2 ширхэг.
 6. Троник(20x20)-тай 4 ширхэг.
 7. 20-ийн хаалт 4 ширхэг.
 8. 45-ын булан 4 ширхэг.
 9. 1.5-тай үүрний таг хийх панер 6 ширхэг.
 10. Үүрний таг тогтоох 4 сантиметрийн угалник 6 метр.
 11. Нугас 10 ширхэг. Төмөр сайтай гагнуур даахуйц байна.
 12. Үүрний тагны бариул 12 ширхэг.
 13. Минжний үүрний таг бөгжлөх 0.6-тай гөлмөн төмөр 10 метр.
 14. 40-ийн труба 6 метр.
 15. 40-ийн хаалт 10 ширхэг.
 16. Ус чийгний хамгаалалттай, гадна байрлуулахад зориулагдсан температур хэмжигч 10 ширхэг

Тав. ЗУРАГ

Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.


МИНЖ ГАДААЛУУЛАХ БАЙРНЫ БУДУУВЧ СХЕМ 1



Тайлбар:

1	Байрны ард хана	6	Минж явах талбай
2	Байрны хажуу хана	7	Минж сэлэх талбай
3	Минжний үүр	8	Сэлэх талбайн ёроол
4	Минжний үүрний зүүн хана	9	Байрны урд хана
5	Минжний үүрний урд хана		


МИНЖ ГАДААЛУУЛАХ БАЙРНЫ ХАЖУУ ТАЛЫН СХЕМ 2



Тайлбар:

1	Байрны ард хана	6	Минж сэлэх талбайн ёроол
2	Минжний үүр	7	Байрны урд хана
3	Минжний үүрний урд хана	8	Ус гадагшлуулах хоолой
4	Минж явах талбай	9	Минжний үүрний таг
5	Минж сэлэх талбайн налуу		

МИНЖНИЙ ҮҮРНИЙ УРД ТАЛЫН СХЕМ 3



Тайлбар:

1	Минжний үүрний баруун хана
2	Минжний үүрний урд хана
3	Минжний үүрний зүүн хана
4	Минж явах талбай
5	Тусгаарлагч хана
6	Минж орж, гарах хэсэг

